


Хууль, эрх зүйн мэдээлэл #7

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль батлагдлаа

Хураангуй



Монгол Улсын Их Хурал 2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр "Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль"-ийг баталсан бөгөөд уг хууль нь хуулиар хориглосноос бусад бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх зарчмыг баталгаажуулж, төрийн оролцоог хязгаарлах, өмчийн эрхийг хамгаалах, шударга өрсөлдөөний орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хангахад зорьсон тухай хуулийн төслийн үзэл баримтлалд дурджээ.

Энэхүү хууль батлагдсанаар 91 хуульд нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд эдгээрээс зөвшөөрлийн тогтолцоог хялбаршуулж зарим үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх эрх зүйн орчинг нэвтрүүлсэн, хөрөнгө оруулагчийн гомдол шийдвэрлэх тогтолцоо болон гадаадын хөрөнгө оруулалтын хэд хэдэн салбарт тогтоосон хязгаарлалтыг арилгасан зэрэг аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаанд нөлөөлөх нэлээдгүй өөрчлөлтүүд оржээ.

Тус хуулиар төрийн бодлого, үйл ажиллагаанд хориглох зүйлсийг тодорхойлсон ба эдгээрээс онцлон дурдвал:

- бизнес эрхлэгчийг нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд албадан татан оролцуулах
- бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хууль, захиргааны хэм хэмжээний актад зааснаас бусад баримт бичиг, түүний бүрдлийг шаардах
- бизнес эрхлэгчийн үйл ажиллагаанд хуульд заагаагүй хяналт шалгалт хийх, хяналт шалгалт хийхээр тогтоосон хугацааг хэтрүүлэх гэх мэт үйл ажиллагаануудыг хийхийг хоригложээ.

Бид энэхүү дугаартаа Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг онцлон хураангуйлан хүргэх бөгөөд цаашдын дугаартаа бусад хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн онцлог зохицуулалтыг цувралаар хүргэх болно.

**Дагалдах
хуулиудын
гол
өөрчлөлтүүд**

**Төрийн
бодлого, үйл
ажиллагаанд
хориглосон
зүйлс**

Холбоо барих:

Abdulkhamid Muminov
Партнер
Татвар, Хуулийн үйлчилгээ
abdulkhamid.m.muminov@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал
Ахлах менежер
Татвар, Хуулийн үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Чойжамцын Цэндмаа
Захирал
Татвар, Хуулийн үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Рэнцэнтавхайн Мандухай
Ахлах хуульч
Татвар, Хуулийн үйлчилгээ
mandukhai.rentsantantavkhai@pwc.com

**Өмгөөллийн
ПрайсуотэрхаусКүүпэрс
Легал ХХН**

Сентрал Тауэр, 6 давхар
601 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
www.pwc.com/mn

Зөвшөөрөл мэдэгдлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
I. Зөвшөөрлийн тогтолцооны шинэчлэлт ба эрсдлийн үнэлгээ

Нэмэлт өөрчлөлтөөр зөвшөөрлийн тогтолцоог бүхэлд нь шинэчилж, өмнө нь тусгай зөвшөөрлөөр зохицуулагдаж байсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрлийн шаардлагад шилжүүлсэн бөгөөд зарим үйл ажиллагааг зөвшөөрлийн шаардлагаас бүрэн чөлөөлж, зарим нь зөвхөн мэдэгдэл хүргүүлэхэд хангалттай байхаар тогтоожээ. Өмнө нь “тусгай” зөвшөөрөлтэйгөөр эрхэлдэг байсан үйл ажиллагаа нь “энгийн” зөвшөөрлийн зохицуулалтад хамаарах болсон байна. Тухайлбал:

- Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа,
- Аудитын үйл ажиллагаа;
- Гаалийн тусгай бүс байгуулах.


Харин зарим тусгай зөвшөөрлөөр эрхэлдэг байсан үйл ажиллагаа нь мэдэгдэл хүргүүлснээр эрхэлж болохоор болжээ. Тухайлбал:

- Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ,
- Банк бус санхүүгийн салбар, төлөөлөгчийн газар, нэгж байгуулах,
- Үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай этгээд нь өөрийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах.

Зөвшөөрөл авах эсхүл мэдэгдэл өгснөөр эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг тогтоохдоо дараах эрсдлийн түвшингээс хамаарч буюу тухайн үйл ажиллагааг төрөөс зохицуулах шаардлага, эдийн засаг болон нийгэмд үзүүлэх үр ашиг, хүний амь нас, эрүүл мэндэд учруулах аюул, мөн хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөлөлийг үнэлгээнд үндэслэхийг заасан.

Эрсдэлийн түвшин		
Бага	Дунд	Өндөр
Мэдэгдэл хүргүүлэхэд хангалттай	Энгийн зөвшөөрөл авах шаардлагатай	Тусгай зөвшөөрөл авах шаардлагатай

II. Мэдэгдэл



www.pwc.com/mn
Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээлэлд үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.
© 2026 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.

II. Мэдэгдэл (үргэлжлэл)

Мэдэгдэл хүргүүлэх

Хэлбэр	"E-business" системд цахимаар
Хугацаа	Үйл ажиллагаагаа эхлүүлэхээс 5-аас доошгүй өдрийн өмнө
Хүлээж авах эрх бүхий этгээд	- Төрийн байгууллага, албан тушаалтан; эсхүл - Төрийн зарим чиг үүргийг хууль, гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээд

III. Зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтад орсон нэмэлт өөрчлөлт

1. Зөвшөөрөл олгох байгууллагад ногдуулах шинэ үүрэг

Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд дараах үүргийг шинээр хүлээлгэжээ. Үүнд:

- Зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад хамаарах газар, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийг зөвшөөрөл хүсэгч эсхүл эзэмшигчийн өмчлөл, эзэмшилд байхыг шаардахгүй байх;
- Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотойгоор зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчээс татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй байхыг шаардахгүй байх.

2. Зөвшөөрлийн хүчинтэй хугацааны өөрчлөлт

Тус хуулийн нэмэлт өөрчлөлтөөр зөвшөөрлийн хүчинтэй хугацааг уртасгаж, тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээс 10 жил, энгийн зөвшөөрлийн хугацааг 3 жилээс 5 жил болгон нэмэгдүүлсэн байна.

3. Зөвшөөрөл сунгах ажиллагааг хөнгөвчилсөн зохицуулалт

Зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнөх 1 жилээс доошгүй хугацаанд зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчөөгүй болох нь эрх бүхий хяналт шалгалтын байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд зөвшөөрөл эзэмшигч нь магадлан шалгах ажиллагаа хийлгүйгээр зөвшөөрлөө сунгуулах боломжтой болсон. Ийм тохиолдолд эрх бүхий байгууллага сунгуулах хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 2 өдрийн дотор зөвшөөрлийг сунгана.

IV. Одоо хүчин төгөлдөр зөвшөөрөл эзэмшигчдийн анхаарах асуудал

Хуульд өмнө нь олгосон зөвшөөрөлтэй эрхэлдэг байсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаанд бүртгэгдсэнд автоматаар тооцох, эсхүл зөвшөөрөл эзэмшигчийг тодорхой хугацаанд шинээр мэдэгдэл хүргүүлэхийг шаардсан шилжилтийн зохицуулалт байхгүй байна. Гэвч нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсноор өмнө нь зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлж байсан үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхлэхдээ мэдэгдлийг цахимаар хүргүүлэх шаардлага үүсэж болзошгүй гэдгийг анхаарах нь зүйтэй.



Бидэнтэй холбогдоорой

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль болон түүний дагалдан гарсан 91 хуулийн нэмэлт өөрчлөлт, түүний хэрэгжилт болон бусад холбогдох хууль эрх зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл авахыг хүсвэл бидэнтэй холбоо барина уу. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг бүрэн эхээр нь харахыг хүсвэл энд дарж танилцана уу. Зөвшөөрөл мэдэгдлийн тухай хуулийг бүрэн эхээр нь харахыг хүсвэл энд дарж танилцана уу.

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээлэлд үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2026 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.